



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Налайх дүүргийн 2 дугаар хорооны орон сууцны 48-67 дугаар байрны гадна инженерийн шугам сүлжээний засварын ажлын хүрээнд бий болсон нийт 75,874,780.54 (далан таван сая найман зуун далан дөрвөн мянга долоон зуун наян төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа, “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Энхтувшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын чазрын
2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн
20 дугаар тогтоопын хавсрагт

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон
"Налайхын дулааны станц" төрийн өмчтэй хувьцаат компанийн үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хөрөнгийн нэр, засварын ажил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бурийн үнэ	Нийт үнэ
2	Налайх дүүргийн 2 дугаар хорооны Орон суучны 48-67 дугаар байрны гадна инженерийн шугам сүлжээний засварын ажил	Дуллааны хос шугам	2020	У/М	158	480,220.13	75,874,780.54
(далан таван сая найман зуун далаан дөрвөн мянга долоон зуун наян төгрөг тавин дөрвөн мөнгө)							

Нийт дүн